



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар АБЗ

Хажуу шинэ-Ус

А.Бямбасүрэнгийн ажлыг хүлээлцэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Ариунболдын Бямбасүрэнгийн ажлыг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Сарангэрэл (Засаг даргын орлогч)  
Гишүүд: Б.Батцэнгэл (Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч)  
Р.Мөнгөн-Өлзий (Эрүүл мэндийн төвийн нярав)  
П.Цэцэгмаа (Эх баригч, бага эмч)  
Г.Болор-Эрдэнэ (Дүн бүртгэгч, бага эмч)

2. А.Бямбасүрэнгийн ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр журмын дагуу акт үйлдэн баталгаажуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Сарангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА Т.АРИУНАА

